

Best Start Kindergarten Assessment Information for parents and carers

Зөв Эхлэл - Бэлтгэл Ангийн Үнэлгээ

Эцэг эх болон асран хамгаалагчдад зориулсан хөтөч

Хүндэт эцэг эх, асран хамгаалагч танаа,

Зөв Эхлэл - Бэлтгэл Ангийн Үнэлгээ нь сургуулиудад Term 1-д явагдах болно.

Зөв Эхлэл - Бэлтгэл Ангийн Үнэлгээг тус муж улсын бүх сургуулиудад хийдэг бөгөөд бэлтгэл анги эхлэх үед тухайн хүүхддийн бичгийн болон тоон чадвар хэр байгааг ойлгоход багш нарт туслах ач холбогдолтой юм.

Сургуульд элсэн суралцаж эхлэх үедээ хүүхэд бүрийн туршлага, ур чадвар, чадавхи өөр өөр байдаг. Зарим хүүхэд бусадтайгаа харьцуулахад номтой танилцсан байх бөгөөд үсэг тоог таньдаг, бүр өөрийнхөө нэрийг бичиж чаддаг, эсвэл 10 хүртэл тоолж чаддаг болсон байдаг.

Зөв Эхлэл - Бэлтгэл Ангийн Үнэлгээг хийснээр багш хүүхэд бүртэй сууж ажиллан тухайн хүүхэд ямар чадвартайг олж харах боломжийг бий болгодог.

Уг үнэлгээ нь ямар нэгэн шалгалт биш ч сургуулийн зүгээс танай хүүхдэд ямар дэмжлэг үзүүлэх боломжтойг тодорхойлоход ихээхэн хэрэг болдог. Хэрэв та хүүхдээ уг үнэлгээнд хамрагдахыг хүсэхгүй байвал сургуультай холбогдоно уу.

Зөв Эхлэл - Бэлтгэл Ангийн Үнэлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээллийг хавсаргасан Мэдээллийн хуудаснаас авна уу.

Зөв Эхлэл - Бэлтгэл Ангийн Үнэлгээний талаар асуух асуулт байвал сургуультай холбогдоно уу.

Орчуулгын Үйлчилгээ

Хэрвээ танд орчуулагч хэрэгтэй бол Утсан Орчуулгын Үйлчилгээний 131 450 дугаарт залган өөрийн хэлний орчуулагчийг хүсээрэй. Орчуулагч сургууль руу холбогдож таныг сургуулийн ажилтан албан хаагчидтай ярилцахад тань туслах болно. Энэхүү үйлчилгээ нь үнэ төлбөргүй юм.

Сургуулийн захирал

